

# ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2025/004/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2025 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: <a href="mailto:erdenebaatara@audit.gov.mn">erdenebaatara@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: <a href="mailto:tegshdelgerb@audit.gov.mn">tegshdelgerb@audit.gov.mn</a> Аудитор: Б.Ариунтуяа Утас:99036832 Цахим хаяг: <a href="mailto:Ariuntuyab@audit.gov.mn">Ariuntuyab@audit.gov.mn</a> Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас:99389208 Цахим хаяг: <a href="mailto:b_myadagmaaa@yahoo.com">b_myadagmaaa@yahoo.com</a> Аудитор Г.Сувд Утас:88115129 Цахим хаяг: <a href="mailto:g.suvd2018@gmail.com">g.suvd2018@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШИНЭ-ИДЭР ДУЛААН ЭРДЭНЭТ ХХК-  
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
А.БААСАНЖАВ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/298  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 12 сарын 02-ны өдрийн 12 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөнд тодотгол оруулан тайлант оны нийт орлогыг 483,439.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 554,405.1 мянган төгрөгөөр баталж 70,965.9 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,918.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж 2 зөвлөмж хүргүүлсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК нь 489,201.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 596,414.9 мянган төгрөгийн зардал гарган, 107,132.6 мянган төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725022023

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,390,295.52	10,948,137.70
1.1.4	Бусад авлага	16,870,430.75	18,878,716.56
1.1.5	Татварын авлага		2,557,246.42
1.1.6	Бараа материал	19,174,019.31	15,814,192.33
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	40,434,745.58	48,198,293.02
1.2.1	Үндсэн хөрөнгө	630,967,017.96	720,663,906.51
1.2.2	Биет бус хөрөнгө	14,132,000.00	16,076,444.44
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	645,099,017.96	736,740,350.96
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	685,533,763.54	784,938,643.98
2.1.1.1	Дансны өглөг	358,523.93	55,405,469.50
2.1.1.2	Цалингийн өглөг	4,570.99	90.00
2.1.1.3	Татварын өр	6,526,588.05	0.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	(0.00)	1,809,016.39
2.1.1.9	Хойшлогдсон албан татварын өр	486,983.45	486,983.45
2.1.1.12	ХАОАТ өглөг	(0.00)	5,212,547.21
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,376,666.41	62,914,106.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,376,666.41	62,914,106.55
2.3.1	Өмч: - төрийн	687,676,437.96	838,676,437.96
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	207,155,817.14	207,155,817.14
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	24,539,500.00	24,539,500.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(241,214,657.97)	(348,050,640.27)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	678,157,097.13	722,024,537.43
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	685,533,763.54	784,938,643.98

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(цэвэр)	482,300,092.64	489,201,335.09
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	415,634,422.80	517,128,780.81
3	Нийт ашиг (алдагдал)	66,665,669.83	(27,927,445.72)
4	Хүүний орлого	29,585.91	81,035.60
5	Ерөнхий ба удирдлагын зардал	84,643,324.28	79,204,849.58
6	Санхүүгийн зардал	79,100.00	81,300.00
7	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(18,027,168.54)	(107,132,559.70)
8	Орлогын татварын зардал	438,078.28	
9	Татварын дараах ашиг (алдагдал)	(17,589,090.26)	(107,132,559.70)
10	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(17,589,090.26)	(107,132,559.70)
11	Орлогын нийт дүн	(17,589,090.26)	(107,132,559.70)

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(223,625,567.71)	695,746,187.39
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(17,589,090.26)	(17,589,090.26)
2024 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	687,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(241,214,657.97)	678,157,097.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(106,835,982.31)	(106,835,982.31)
Өмчид гарсан өөрчлөлт	151,000,000.00	0.00	0.00	0.00	151,000,000.00
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	838,676,437.96	207,155,817.14	24,539,500.00	(348,050,640.28)	722,321,114.82

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>529,628,933.60</b>	<b>536,044,535.99</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	529,237,888.60	536,044,535.99
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	391,045.00	0.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>500,263,291.01</b>	<b>510,256,929.41</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	180,816,821.00	185,969,118.91
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	52,846,046.43	53,658,623.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	77,346,875.00	39,145,700.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	700,707,187.62	70,273,115.22
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	47,104,635.20	114,503,998.40
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	39,078,480.76	44,741,511.41
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	82,875.00	133,900.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,363,245.00	1,830,962.43
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>29,365,642.59</b>	<b>25,787,606.58</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,701,585.91</b>	<b>81035,60</b>
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,672,000.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	29,585.91	81035,60
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>32,083,000.00</b>	<b>19,310,800.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	32,083,000.00	19,310,800.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,381,414.09)</b>	<b>(19,249,283.19)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,015,771.50)</b>	<b>6,557,842.18</b>
<b>5</b>	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>5,409,025.61</b>	<b>4,390,295.52</b>
<b>6</b>	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>4,390,295.52</b>	<b>10,948,137.70</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
1	Халаалт	480,766,483.00	484,437,297.82	101.00	3,670,814.82
2	Цэвэр ус түгээх /худаг/	1,636,356.00	3,673,128.18	224.00	2,036,772.18
3	Байр талбайн түрээс	1,036,362.00	1,090,909.09	105.00	54,547.09
4	Хүүгийн орлого		81,035.60		81,035.60
	<b>Орлогын дүн</b>	<b>483,439,201.00</b>	<b>489,282,370.69</b>	<b>101.00</b>	<b>5,843,169.69</b>
1	Цалин	208,679,594.00	202,397,040.00	97.00	(6,282,554.00)
2	НДШ	30,876,000.00	30,875,293.32	100.00	(706.68)
3	Нүүрс худалдан авах	51,306,820.00	58,147,275.00	113.00	6,840,455.00
4	Нүүрс тээвэрлэлт	102,909,090.00	111,051,304.16	108.00	8,142,214.16
5	Түлш шатахуун	13,181,826.00	12,983,467.21	98.00	(198,358.79)
6	Цахилгааны зардал	54,681,818.00	54,646,310.45	100.00	(35,507.55)
7	Хөдөлмөр хамгаалалын зардал	18,096,000.00	16,889,227.27	93.00	(1,206,772.73)
8	томилолт	650,000.00	650,000.00	100.00	0.00
9	Бичиг хэрэг	1,200,000.00	532,951.38	44.00	(667,048.62)
10	Ойёёёё	1,605,000.00	1,442,000.00	90.00	(163,000.00)
11	Төлбөр хураамж аудитын зардал	2,600,000.00	2,600,000.00	100.00	0.00
12	Засвар үйлчилгээ	9,038,000.00	7,797,500.48	86.00	(1,240,499.52)
13	ТУЗ-ийн зардал	7,000,000.00	6,983,409.00	100.00	(16,591.00)
14	ТХ Татвар даатгалын зардал	300,000.00	203,400.00	68.00	(96,600.00)
15	Газар ус ашигласны төлбөр	650,000.00	647,277.00	100.00	(2,723.00)
16	ЭХЗЗ-ийн үйлчилгээний зардал	1,831,000.00	1,830,962.43	100.00	(37.57)
17	ҮХХ-ийн татварын зардал	300,000.00	250,000.00	83.00	(50,000.00)
18	Тэтгэмж урамшуулал, нийгмийн асуудал	9,500,000.00	9,237,727.51	97.00	(262,272.49)
19	Элэгдэлийн зардал	40,000,000.00	77,168,485.18	193.00	37,168,485.18
20	Банкны шимтгэл	0.00	81,300.00		81,300.00
21	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	554,405,148.00	596,414,930.39	108.00	42,009,782.39
22	Татварын өмнөх ашиг, /алдагдал/	(70,965,947.00)	(107,132,559.70)		(36,166,612.70)

## 2 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 17,909.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Үр дүнгийн тайланд орлого 28.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсаныг залруулсан
- 58 харилцагчтай холбогдох 17,880.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүйг аудитын явцад тооцоо нийлж баталгаажуулсан.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26 гүйлгээ, зарлагын 20 гүйлгээ, ХАА-ны төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;*” заалт, 6 дугаар зүйлийн

6.4.5 “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*” заалтууд болон Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4.1.2, 4.1.8, 4.1.9, заалтуудтай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлж ажиллах

#### **2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Тайлант жилд бизнес төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 “*Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.*”, 48 дугаар зүйлийн 48.2.1 “*Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;*” заалт, Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан “*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам*”-ын 2.11 “*Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.*” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, төсөвт өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг оруулж батлуулж байх.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд орлого зөрүүтэй тайлагнагдсан	1	37.5			1	37.5	1	37.5		
58 харилцагчтай холбогдох 17880.6 мянган төгрөгийн авлага тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	17,880.6	1	17,880.6			1	17,880.6		
Дүн	2	17,918.1	1	17,880.6	1	37.5	2	17,918.1		

### 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26 гүйлгээ, зарлагын 20 гүйлгээ, ХАА-ны төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	-
Тайлант жилд бизнес төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй	1						1	
Дүн	1	-					1	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			